

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 23 ДУГААР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ /2025-11-20/

Монголын ОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн 23 дугаар хуралдаан 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 10.00 цагт Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны 2 давхарын хурлын танхимд зохиогдов.

Хуралдаанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Орчны бодлого, үнэлгээний газрын ахлах шинжээч О.Амарсанаа, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтэн Б.Туул, Үндэсний статистикийн хорооны статистикч Б.Энхболд, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нарийн бичгийн дарга Б.Галбадрах, "Эрдэнэс Монгол" нэгдлийн менежер Ц.Батсүрэн, Монголын уул уурхайн үндэсний ассоциацын үйл ажиллагаа хариуцсан менежер Б.Саранцацралт, Нүүрс ассоциацын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэнэцэцэг, Рио Тинто компанийн гадаад харилцааны зөвлөх Ч.Цэлмэг, "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн ерөнхий нягтлан Ц.Болормаа, "Энержи Ресурс" ХХК-ийн олон нийтийн харилцааны менежер З.Сугармаа, "Оюу Толгой" ХХК-ийн орон нутгийн харилцааны менежер Б.Сугар, "Эрдэнэс критикал минералс" ХХК-ийн мэргэжилтэн Б.Батсайхан, "Монполимет" ХХК-ийн менежер Б.Октябрь, "Эрдэнэт Үйлдвэр" УҮГ-ын Төлөөлөгчийн газрын менежер Ц.Ганболд, "Хүний эрх, хөгжил төв" ТББ-ын тэргүүн Г.Уранцоож, "Нээлттэй нийгэм форум"-ын менежер О.Сэлэнгэ, "Захиргааны шинэ санаачилга" ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв, "Ховдын толь" ТББ-ын тэргүүн Т.Төрмөнх, "Монголын байгаль эхийн аврал сан" ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг, Эрхүү хотын "УААДС-ийг төгсөгчдийн холбоо"-ны төлөөлөл Ц.Чагнаадорж, МБИОЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Чинзориг нар оролцов. Үндэсний зөвлөлийн нийт 29 гишүүнээс 22 гишүүн оролцож, ирц 76 хувьтай байв.

Мөн "СИКА ХХК"-ийн дэд захирал Г.Эрдэнэ, хэлтсийн захирал Т.Түмэнчимэг, судалгааны менежер Б.Удвал, О.Энхзул болон "Гроут Финанс Аудит" ХХК-ийн аудитор Т. Ганбат, ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар ОУИТБС-ын санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, мэдээлэл технологийн зөвлөх Х.Хулан нар энэ хуралдаанд оролцсон байна.

Хуралдааныг АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв даргалж, нээж үг хэлэв. /Нээлтийн үгийг хавсаргав/.

"СИКА" ХХК-ийн дэд захирал Г.Эрдэнэ Монгол Улсын ОУИТБС-ын 19 дүгээр буюу 2024 оны нэгтгэл тайланг танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/.

**Б.Дашпүрэв:** За баярлалаа. Тайлантай холбогдолтой гишүүд асуулт асууж, хариулт авъя аа.

**С.Цэрэнпүрэв:** За энэ өдрийн мэнд хүргэе. Цолмон дарга аа, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас манай энэ хуралд суудаг юм уу?

**Ш.Цолмон:** Үгүй.

**С.Цэрэнпүрэв:** Оруулж байх хэрэгтэй шүү дээ. Энэ төрийн өмчит компаниуд маш их асуудалтай байна шүү. Үнэлгээ хийсэн, шалгалтын дүнгээс харахад ердөө 61 төрийн өмчит компани байна лээ. Тэдгээрийг зохицуулагч байгууллага тайлбараа маш сайн өгдөг байх хэрэгтэй гэж ойлгож байна. Аудиторуудад ч мөн адил тухайн байгууллагуудад тодорхой мэдээлэл өгөхийг шаардсан байх гэж бодож байна.

**Б.Чинзориг:** Өглөөний мэнд. Илтгэл, тайлбаруудыг сонслоо. Өмнөх жилүүдтэй харьцуулахад тодорхой ахиц, үр дүн гарсан байна. Ялангуяа орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй холбоотой санал, гомдол, зөвлөмжүүдийг авах асуудал дээр анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Би өмнөх хуралдаан дээр орон нутгийн 20 аж ахуйн нэгж, ямар ямар аймгуудаас хамрагдсан талаарх мэдээллийг өгөх, сайжруулах санал өгч байсан. Гэвч тухайн мэдээлэл тайланд арай дутуу туссан байх шиг байна. Орон нутгийн болон бусад аж ахуйн нэгжүүдийн тайлангийн мэдээллийн хувьд мөн дутагдал илэрч байгаа бололтой. Ер нь орон нутгийн түвшинд ажиллаж буй төрийн байгууллагууд ил тод байдлыг хангах, тайлагналын үйл явц хэрхэн явж байгаа талаар мэдээллээ сайжруулах шаардлагатай. Энэ асуудалтай холбоотой зөвлөмж, дүгнэлтүүдийг тайланд тусгасан байгааг анзаарсан. Цаашид энэ чиглэлд илүү анхаарч ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн орон нутгийн иргэд болон төрийн бус байгууллагуудаас мэдээлэл хүлээн авах, ил тод байдлын мэдээлэлд иргэдийг хэрхэн оролцуулах талаарх журамд тодорхой өөрчлөлт оруулах шаардлага байна. Иргэдээс мэдээлэл яаж авах вэ, орон нутагт ажиллаж буй иргэдийн мэдээллийг хэрхэн хүлээн авах вэ гэсэн асуудалд бодлогын түвшний сайжруулалт хийх хэрэгтэй байна.

**Т.Төрмөнх:** Сайн байна уу, Ховдын толь ТББ. Урьд жилүүдэд нэгтгэл тайлангууд нэлээд бүтээлч, үр дүнтэй зөвлөмжүүдийг гаргаж ирдэг байсан. Энэ жилийн нэгтгэл тайлангийн хувьд ч мөн адил ач холбогдолтой, оновчтой зөвлөмжүүд гарсан байна. Гэвч эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин хангалтгүй байгаа нь анзаарагдаж байна. Тиймээс зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтийг хангах механизмыг бий болгох асуудал чухал байгааг би хэлмээр байна. Хоёрдугаарт энэ чиглэлд хариуцлагын механизм шаардлагатай гэж үзэж байна.

**Г. Эрдэнэ:** За баярлалаа. Таны асуултад болон өмнөх хүмүүсийн асуултуудад хариулахад бид тайланд өөрсдийн зүгээс тодорхой зөвлөмжүүдийг дэлгэрүүлэн оруулах боломжтой. Энэ ажлыг судлаачид болон аудитын багийнхан хамтран хийж байгаа тул зөвлөмжийн хэрэгжилтийг хангахын тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстойг өөрсдийн түвшинд тодорхой гаргаж өгөх боломжтой. Харин эдгээр зөвлөмжийн дагуу бодит арга хэмжээ авах, хэрэгжилтийг хангах талаар шийдвэр гаргах нь холбогдох төрийн байгууллагууд болон шийдвэр гаргах түвшний удирдлагын бүрэн эрхийн асуудал юм. Таны саналын дагуу бид зөвлөмжөө илүү дэлгэрүүлж, тодорхой болгож тайланд оруулж өгье. Компаниудын сонголт,

аймгуудын хувьд бид тайлангын хүснэгтээ дэлгэрэнгүй оруулсан байгаа, та тэндээс хараарай.

**Б. Дашпүрэв:** За өөр асуулттай гишүүн байна уу?

**Гишүүд:** Байхгүй.

**Б.Дашпүрэв:** За Сика компанийнханд баярлалаа. Дараагийн хэсэгт Монголын олборлох үйлдвэрлэлийн дотоод байдлын санаачлагын ажлын албаны 2025 оны ажлын төлөвлөөний биелэлт, 2026 оны ажлын төлөвлөгөөний төслийг ажлын албаны зохицуулагч Цолмон танилцуулна. /Танилцуулгыг хавсаргав/.

**Б.Дашпүрэв:** За, гишүүд тайлантай холбоотой асуулт хариулт байвал асууна уу.

**Б.Чинзориг:** Энэ хуулийг хэрхэн батлуулах вэ? Тэгээд энэ тал дээр нэлээн анхаарлаа төвлөрүүлж, түргэвчилж ажиллах, ямар боломжит гарцуудыг хайж байгаа, тэр талаар тодорхой асууж тодруулах хэрэгтэй байна. Стандартыг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Уул уурхайн аж ахуйн нэгжүүд стандартыг хэрхэн мөрдөх, яамнаас ямар бодлого баримтлах вэ гэдэг дээр анхаарал хандуулах шаардлагатай. Энэ тал дээр стандарт, гэрээ барихгүй бол бид олон улсад хоцрогдож байгаа нь тодорхой байна. Тиймээс энэ асуудалд анхаарлаа хандуулж, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах талаар санал хэлэх нь чухал байна. Ингэж ажилласнаар ажлаа эрчимжүүлэх боломжтой. За, баярлалаа.

**Т.Төрмөнх:** Тэгэхээр энэ хууль нэгэнт зайлшгүй шаардлагатай гэж үзэж, төсөл боловсруулаад хэлэлцүүлэх бэлэн болсон нөхцөлд батлагдахгүй байгаа нь ямар шалтгаантай вэ? Тэр шалтгааныг арилгахын төлөө ажиллах ёстой биш үү? Энэ бол нэг чухал асуулт. Хоёрдугаарт, ОУИТБС-н жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх баталгааны асуудал байна. Энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг яам хариуцаж, баталгааг хангах ёстой. Тэгэхээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам 2026 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх баталгааг хариуцах ёстой. Энэ баталгаа байгаа юу? Тухайлбал, өнгөрсөн жилийн буюу 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсвийг нь баталж өгөөгүй шүү дээ. Өнөө жил төсвийг нь баталж өгөх юм уу, үгүй юм уу гэдгээ одоо хариулаач.

**Б. Дашпүрэв:** За баярлалаа. Хууль эрх зүйн хувьд бид өөрсдийн хууль эрх зүйн орчныг боловсруулж, бие даасан хууль батлах чиглэлд ажиллаж байна. Одоогоор бодлогын ажил үргэлжилж байгаа. Хууль батлуулахад яагаад боломжгүй байх вэ гэвэл, олон улсын түвшинд бие даасан хуультай улс цөөн байдаг. Жишээлбэл, Замби, Либериа зэрэг улсууд бие даасан ил тодын хуультай, бусад улс орнууд өөр хууль, журмаараа тодорхой хэмжээний ил тод, нээлттэй зохицуулалтыг хийдэг. Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуулиуд амархан, шууд батлагдах асуудал биш. Гэхдээ зорилгын хувьд бид бие даасан хууль боловсруулах чиглэлд бодлого, ажлаа түлхээд явна. Хэрэв бие даасан хууль батлагдахгүй бол, бид одоогийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулалтыг хийгээд явна.

Том бодлогын өөрчлөлтүүд, багц хуулийн шинэчлэлүүд яригдаж байгаа ч, Их Хурлын босгыг давж батлагдах нь төвөгтэй, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал. Иймээс бид Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс татгалзаж, нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулж, үндсэндээ 50%-аас дээш өөрчлөлт оруулахгүйгээр гол зохицуулалтуудаа хийж байна.

Түүнчлэн 2026 оны төсөвт олборлох салбарын ил тод байдлыг дэмжих чиглэлээр тодорхой хэмжээний санхүүжилт батлуулсан бөгөөд энэ нь үйл ажиллагааг үргэлжлүүлэх, ил тод байдлыг сайжруулахад чиглэгдсэн.

Түүрүүн хэлсэнчлэн, компаниуд өөрсдийн ил тод, нээлттэй байдлыг хангах, төрийн авлигаас ангид байх, дүрэм журмаа мөрдөх, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод мэдээлэх талд дутагдалтай байгаа. Энэ асуудлыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бодлогоор дэмжиж, шахаж ажиллаж байна. Гэсэн ч салбарыг ойлгуулах, иргэдэд мэдээлэх ажил дутагдалтай байна. Ихэнх инженер, техникийн ажилчид зөвхөн өөрсдийн өдөр тутмын ажилдаа төвлөрч, нийгэмд өөрсдийгөө ойлгуулах талаас сул байгаа нь компаниудын идэвхийг бууруулж байна. Иймд тайлан, мэдээ мэдээллийн хүрээнд нийгэмд ойлгуулах, менежментийн арга хэрэгсэл ашиглах шаардлага байна. Гишүүдийн санаачилгаар тодорхой хэмжээнд ажлууд явагдаж байгаа ч, нийтээр ойлголт дутагдсанаас үр дүн хангалтгүй байна. Энэ нь олон улсад ч чухал, үр нөлөөтэй. Монгол Улсын авлига, компанийн дүрэм журмын хэрэгжилт, төрийн хүнд суртал зэрэг нь салбарын ил тод байдалд нөлөөлж байна. Гэхдээ компаниуд дүрэм журмаа мөрдөж, ил тод байдлаа дээшлүүлж эхэлснээр энэ сайн үр дүн бий болох боломжтой.

Тиймээс компаниудын үйл ажиллагааг төсөв, жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлтэй уялдуулж, шаардлагатай санхүүжилт, татварын зохицуулалт хийж, нийгмийн чиглэсэн үйл ажиллагаанд оролцох боломжийг олгох хэрэгтэй байна. Үйл ажиллагаагаа хангалттай төсөвтэйгээр явуулах боломжтой, нийгмийн оролцоо, итгэл үнэмшлийг бий болгож, бодлогын удирдамжаар хангахад анхаарах ёстой.

Өнөөдрийн хурлууд, гишүүдийн оролцоо чухал бөгөөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, салбарын ил тод байдлыг дээшлүүлэх үйл ажиллагааг дэмжих шаардлагатай. За баярлалаа.

**О.Сэлэнгэ:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Нээлттэй нийгэм форумаас Сэлэнгэ гэж хүн байна. Ерөнхийдөө манайх тайлантай холбоотой саналуудаа урьдчилаад тодорхой хэлсэн байгаа. Одоо нэмэлт, ороогүй саналуудаа товч танилцуулъя. Юуны өмнө, ОУИТБС-ын 2024 оны тайлан боловсруулахад холбогдох талуудтай хамтран ажиллаж, иргэний нийгмийн байгууллагаас санал авч, компаниудыг хамруулсанд талархал илэрхийлж байна. Тайлангаас харахад мэдээлэл, тодруулга өгөх байдал суларсан байна гэж дүгнэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор ОУИТБС-ын хэрэгжилтийг баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 заалтаар тайлагнах үүргээ биелүүлээгүй тохиолдолд, Зөрчлийн тухай хуулийн 7.11-ийн 2.2-д заасанчлан хариуцлага ноогдуулах боломж бүрэн бий. Үүний дагуу, ил тод байдлын тайлан гаргаагүй, нэгтгэл тайланд хамтран ажиллаагүй компаниудад хуулийн хариуцлага хүлээлгэх нь санаачилгын хэрэгжилтийг сайжруулахад чухал гэж үзэж байна. Түүнчлэн, төрийн байгууллагуудын оролцоо сул байгааг тайланд тэмдэглэжээ. Жишээ нь, Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам шаардлагатай мэдээллийг өгөөгүй байна. Үүнийг сайжруулах арга замыг тодорхойлох шаардлагатай.

Тайлангийн 4.3-ын хэсэг буюу хүснэгт 37- оос харахад тусгай зөвшөөрлийг нөхөн олгох байдал хэвшмэл болсон байна. ОУИТБС тухайн жилд тогтоосон дүрэм журмаас гадуур зөвшөөрөл олгосон эсэхийг судалж, үндэслэл, шалтгааныг тайланд тусгах шаардлагатай. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг тогтоосон талбайд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд төсвөөс зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх гэрээ байгуулагддаг. Хэрэв гэрээ байгуулаагүй, эсвэл гэрээгээр тодорхойлсон нөхөн төлбөрийг хугацаанд төлөөгүй бол тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болно. Одоогоор ойролцоогоор 40 орчим компани гэрээ байгуулаагүй байна.

Эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээлэлд, ОУИТБС-ын цахим систем, тайлагнасан болон улсын бүртгэлийн байгууллагын мэдүүлсэн мэдээлэл зэрөөд байгааг түүврийн аргаар шалган тодорхойлох шаардлагатай. Улсын бүртгэлийн хувьд эцсийн өмчлөгчийг хувь хүний түвшинд тодорхойлж, тайлагнах шаардлага тавигддаг ч компаниуд мэдээллээ өгөхгүй байгаа шалтгааныг тодруулах хэрэгтэй.

Гэрээний ил тод байдалд, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулж, төрийн өмчийн баялаг, байгалийн баялагтай холбоотой аливаа гэрээ, хэлэлцээр, үйл явцад ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх, нууцлах аливаа тохиолдлыг хориглох зөвлөмжийг тусгах шаардлагатай.

ОУИТБС-ын хэрэгжилтийг хариуцсан гол байгууллага болох Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, ил тод гэрээ, цахим сангийн үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг албажуулах хэрэгтэй.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай сангийн үлдэгдлийн мэдээлэлд, 2024 онд хийгдсэн орлого, зарлагын мэдээллийг дэлгэрэнгүй тусгах шаардлагатай байна. Мөн төрийн мэдээллийн сангийн цахим холбоосыг тайланд оруулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үнэн зөв байдал, хэрэгжилтийг хянахад чухал мэдээллийг нээлттэй болгох шаардлагатай.

**Ш.Цолмон:** Эдгээр саналуудыг СИКА-д ажлын хэсгийн хурлын дараа өгсөн. Сая зарим нь бас тусгагдсан байх шиг байна. Дахин СИКА-с тодруулъя.

**Г.Уранцоож:** Энэ жилийн тайлан болон нэлээн олон жилийн өмнөх зөвлөмжүүдтэй холбоотой асуулт байна. Нэгд, өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдалд хийсэн үнэлгээ гэж байна уу гэдэг нь тодорхойгүй байна. Нэлээн олон жилийн өмнө гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг одоо хэрхэн үнэлж байгаа вэ гэдэг тал дээр мэдээлэл байхгүй байна. Хоёрт, энэ зөвлөмжүүдийг Засгийн газарт, ерөнхий сайдад танилцуулдаг уу гэдэг асуулт байна. Хэрэв одоо танилцуулдаггүй бол, танилцуулах хэрэгтэй. Мөн эрх зүйн орчны хувьд хуульд нь өөрчлөлт оруулах эсвэл бусад хуулиуддаа зохицуулалт хийх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох ёстой.

Нөгөө асуудал нь, Үндэсний зөвлөлийг шинэчлэн байгуулах, механизмыг өөрчлөх санаачилга юм. Энэ нь зөв алхам. Гэхдээ одоогийн Үндэсний зөвлөл, түүний үйл ажиллагаа, үр дүн, ач холбогдлыг үнэлэх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ бол үнэхээр чухал ажил. Тиймээс үүнийг улам сайжруулах шаардлагатай. Шинэ механизмыг бий болгох гэж байгаа бол, яг ямар байх ёстойг тодорхойлохын тулд үнэлгээ хийх шаардлагатай.

**Ш.Цолмон:** Хуулийн төслийг Их хурлын даргад тухайн үед танилцуулж байсан. Ерөнхий сайдад танилцуулж байгаагүй.

**Б.Дашпүрэв:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас миний гарын үсэгтэй, яаралтай бичиг гаргаж мэдээллээ ил тод, нээлттэй болгох тухай болон мэдээлэл ирүүлэх хугацааг тодорхой заасан албан мэдэгдлийг хүргүүлье. Мөн Татварын ерөнхий газар руу ч гэсэн ийм чиглэлийн бичиг явуулья Хувь хүний хандлага, эс үйлдэхүй гаргаж суух боломжгүй учраас энэ ажлыг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай.

Иймээс гэрээгээ байгуулаагүй компаниуд руу бүгдэд нь албан бичиг явуулж, гэрээгээ ил тод, нээлттэй болгоогүй компаниудад хуулийн хүрээнд арга хэмжээ тооцохыг сануулсан бичгийг давхар хүргүүллье. Мөн мэдээллээ нуух, хугацаандаа ирүүлэхгүй байх нь хуулийн хариуцлагатай болохыг захиа мэдэгдэлд тодорхой дурдья. Төрийн захиргааны төв байгууллагын хувьд бид тодорхой хэмжээний хариуцлага тооцож, шаардлагатай шахалтыг хүргүүлэх ёстой. Ингэхгүй бол сайн дурын зарчмаар хэн хүссэн нь оролцож, хэн нэг нь тааллаараа хийх зэрэг замбараагүй байдал бий болж, бидний ажил зөвхөн гуйж, ятгаж суудаг байдал руу шилжих эрсдэлтэй. Ийм байдал үүсэхээс сэргийлэх хэрэгтэй.

Мөн байгаль орчинтой холбоотой мэдээллийг тодорхой хугацаатай үүрэг, даалгавартайгаар авч, нээлттэй болгож, тайланд тусган явуулах нь зүйтэй. Гишүүд ч гэсэн энэ ажлын хүрээнд идэвхтэй оролцож байгаад талархаж байна. Сая хэлсэн санал санаачилга маш чухал. Ингээд бүх ажлаа урсгалын дагуу явуулж байна гээд зүгээр хандах биш, гишүүн бүр хариуцлагатай, идэвхтэй оролцож, бидэнд байгаа хугацаанд тайлангаа хэрхэн сайжруулах вэ гэдэгт бодитой хувь нэмэр оруулах хэрэгтэй.

Хуралд орж ирчихээд өөр зүйл бодоод суухгүй, оролцоо, санаачилга гаргаж ажиллах шаардлагатай. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас

төлөөллийг оролцуулах, бусад шаардлагатай төрийн байгууллагууд болон бусад компаниудын төлөөллийг бүрэн хамруулах зохион байгуулалтыг Цолмон дарга яаралтай авч хэрэгжүүл. Төлөөлөл бүхий бүх оролцогч хуралдаа идэвхтэй оролцож, санал санаачилгатай, тайлан танилцуулгатай танилцаж, цаг хугацаанд нь шаардлагатай байр сууриа илэрхийлдэг байхаар зохицуулах хэрэгтэй байна.

Энэ бүхэн Монгол Улсын болон Засгийн газрын нүүр царай, олборлох салбарын олон талт оролцооны ажлын бодит үр дүн юм. Тиймээс өмнө хэлсэнчлэн, энэ чиглэлд яам манлайллаа харуулж ажиллах зайлшгүй шаардлагатай. Ингэж байж төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Та бүхэн зөвхөн манай салбарын ажил гэлтгүй, бүх оролцогч талын идэвхийг нэмэгдүүлж, ил тод, нээлттэй, шударга байдлыг бүрдүүлэхэд анхаарч ажиллах ёстой. Цолмон дарга, холбогдох мэдээлэл боловсруулах, сургалт судалгааны ажлуудыг хийхдээ хэвлэл мэдээллийн байгууллагуудыг заавал татан оролцуул. Ил тод байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга бол олон нийтэд мэдээлэх юм. Энд байгаа гишүүд гадагш гарч мэдээлэл өгөхөд олон нийт, хэвлэл мэдээлэл “яг юу болж байна вэ” гэдгийг тодорхой ойлгох ёстой.

Компаниуд гэрээгээ ил тод гаргахгүй, мэдээллээ нээлттэй болгохгүй байгаа асуудал нь вебсайт болон бусад мэдээллийн сувгуудаар харагдаж байгаа нь тодорхой. Гэрээ байгуулаагүйн улмаас компанид хуулийн хариуцлага тооцох нөхцөл үүсэж байгаа тухай мэдээлэл ч олон нийтэд ойлгомжтой хүрэх хэрэгтэй. Ийм мэдээлэл нийтэд нээлттэй болсноор компаниуд өөрсдөө ч засаглал, сахилга бат, дотоод журамдаа анхаарч эхэлдэг. Авлигаас ангид байх, дүрэм журмыг сахих нь зөвхөн төрийн биш, компанийн өөрсдийн хариуцлага гэдгийг ойлгох ёстой. Иймд олон талт, системтэй ажлуудыг давхар сайжруулах нь чухал гэдгийг онцолъё.

**Б. Дашпүрэв:** За ингээд Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлийн төслийг та бүхэнд танилцуулья.

#### **Хурлын дүгнэлт, шийдвэр:**

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлд хэлэлцсэн нь Монголын Олборлох үйлдвэрийн эд далд байдлын санаачилгын 2024 оны буюу 19 дүгээр нэгтгэл, тайлангийн танилцуулга 2025 оны ажлын төлөвлөгөөний биелэлт 2026 оны ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцлээ.

Шийдвэрлэсэн нь, Үндэсний зөвлөлийн 23 дугаар хуралдаанаас дараах шийдвэрүүдийг гаргахаар тогтов. Үүнд 2024 оны буюу 19 дүгээр нэгтгэл тайланг Үндэсний зөвлөлийн гишүүдийн санал, зөвлөмжийг хавсарган батлах, хэвлэн нийтлэхийг зөвшөөрөх, 2025 оны 23 тоот зөвлөх үйлчилгээний гэрээний үлдэгдэл 30% буюу 32 сая та 700 мянган төгрөгийг төлөхийг ажлын албанд зөвшөөрөх, 2025

оны ажлын төлөвлөгөөний төлөвлөгөөний биелэлт 2026 оны ажлын төлөвлөгөөний төслийг Үндэсний зөвлөлийн гишүүдийн санал, зөвлөмжийг тусган батлах, хэвлэн нийтлэхийг Ажлын албаны зохицуулагч Цолмонд зөвшөөрөв гэсэн ийм хуралдааны тэмдэглэл, мөн энэ дээр Цолмонд даалгахаар нэмэлт 4 дэх шийдвэрийг нэмье гэсэн ийм санал байна. Үүнтэй холбогдолтой гишүүдийн санал байна уу?

**Гишүүд:** Нэмэлт саналгүй. Дэмжиж байна.

Хуралдаан 12.00 цагт өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга:



Б.Дашпүрэв


**Тэмдэглэлийн хянасан:**

АҮЭБЯ-ны СХОХ-ийн дарга



Т.Амартүвшин

ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ОҮИТБС-ын Ажлын албаны Мэдээлэл технологийн зөвлөх - 2



Х.Хулан